



ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХКОМПАНИ

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН


Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: СТА-2026-239-ААН

Улаанбаатар хот
2026 он

ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Хуудас: 1



Монголсекюритиес ҮЦК ХК-ийн
Удирдлага танаа

ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Амарын гудамж-2,
Адмон групп ХХК-н байр 206 тоот
Утас: +976-77114235, +976-99994235
И-мэйл: audit@tsebeconsulting.mn
Вэбсайт: www.tsebeconsulting.mn

2026-08-25 № _____
танай _____-ны № 26/239 -т

ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын дүгнэлт:

Бид Аудитын тухай хуулийн 9.1.1-д заасны дагуу Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын хүрээнд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл:

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЕЗОУСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, Монгол улсын аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг шаардлагын дагуу аудит хийгдэх компаниас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага:

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох стандарт, хуульд нийцүүлэн боловсруулж, тогтмол мөрдөж ажиллах нь компанийн удирдлагын үүрэг болно.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэж шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг бий болгон ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, байгууллагын үйл ажиллагааны болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурь зарчмыг хангаж ажиллах нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийж ажиллах нь байгууллагын удирдлагын хариуцлага юм.

СТА-2026-239-АА/1

ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

Хуудас: 2

0000000729

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага:

Аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгын үндэслэлийг тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Санхүүгийн тайлангууд нь алдаа, залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдэлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг.


Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллууд, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж бид итгэж байна.

Хэрэглээний хязгаарлалт:

Энэхүү тайлан нь Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан ба аливаа нэгэн өөр зорилго агуулаагүй болно.

ЗАХИРАЛ



Д.ЭНХБААТАР
/Аудитор, МНБ/

1.АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**1.1 Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,293,407.85	13,257,407.85
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	177,128.25	177,128.25
1.1.5	Санхүүгийн хөрөнгө	1,663,137,599.59	1,589,095,754.99
1.1.5.1	Арилжааны үнэт цаас	12,293,899.59	12,293,899.59
1.1.5.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	1,650,843,700.00	1,576,801,855.40
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,676,608,135.69	1,602,530,291.09
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	9,728,800.00	9,728,800.00
1.2.1.1	Хуримтлагдсан элэгдэл	(6,407,902.02)	(7,380,702.02)
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,320,897.98	2,348,097.98
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,679,929,033.67	1,604,878,389.07
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	307,626,937.38	388,905,764.78
2.1.1.3	Татварын өглөг	11,853,686.08	16,144,715.68
2.1.1.4	Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	24,836,599.32	461,763.32
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	344,317,222.78	405,512,243.78
2.2	Өр төлбөрийн нийт дүн	344,317,222.78	405,512,243.78
2.3	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3.2	Өмч-Хувийн	300,000,000.00	300,000,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,650,843,700.00	1,576,801,855.40
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(615,231,889.11)	(677,435,710.11)
2.3.9.1	Тайлангийн үеийн ашиг	(60,856,808.00)	(62,203,821.00)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(554,375,081.11)	(615,231,889.11)
2.3.10	Эздийн өмчийн дүн	1,335,611,810.89	1,199,366,145.29
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,679,929,033.67	1,604,878,389.07

1.2 Аудитлагдсан орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үйл ажиллагааны орлого	-	30,000.00
1.4	Брокерын үйл ажиллагааны орлого	-	30,000.00
2	Борлуулалт, маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал	60,856,808.00	62,233,821.00
2.1	Ажиллагсдын цалингийн зардал	48,240,000.00	51,516,000.00
2.2	Аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн даатгалын зардал	4,832,400.00	5,069,460.00

2.3	Албан татвар төлбөр хураамжийн зардал	1,800,000.00	2,065,000.00
2.5	Шуудан холбооны зардал	-	2,574,561.00
2.6	Мэргэжлийн үйлчилгээний зардал	24,000.00	36,000.00
2.8	Ашиглалтын зардал	4,987,608.00	-
2.11	Элэгдэл хорогдлын зардал	972,800.00	972,800.00
15	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(60,856,808.00)	(62,203,821.00)
16	Орлогын татварын зардал	-	-
19	Татварын дараах ашиг (алдагдал)	(60,856,808.00)	(62,203,821.00)

1.3 Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	300,000,000.00	1,021,269,457.90	(554,375,081.11)	766,894,376.79
Өмчид гарсан өөрчлөлт	-	629,574,242.10	-	629,574,242.10
Тайлант үеийн үр дүн	-	-	(60,856,808.00)	(60,856,808.00)
2024 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	300,000,000.00	1,650,843,700.00	(615,231,889.11)	1,335,611,810.89
Өмчид гарсан өөрчлөлт	-	(74,041,844.60)	-	(74,041,844.60)
Тайлант үеийн үр дүн	-	-	(62,203,821.00)	(62,203,821.00)
2025 оны 12-р сарын 31-рх үлдэгдэл	300,000,000.00	1,576,801,855.40	(677,435,710.11)	1,199,366,145.29

1.4 Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	46,504,306.38	30,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	30,000.00
1.1.3	Татаас санхүүжилтийн орлого	46,504,306.38	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	46,528,344.00	81,344,824.40
1.2.1	Ажиллагсад төлсөн мөнгө	39,716,736.00	42,459,266.40
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	-	34,210,000.00
1.2.3	Ашиглалтын зардалд төлсөн	4,987,608.00	2,574,561.00
1.2.6	Зохицуулалтын хөлс, шимтгэл хураамжид төлсөн мөнгө	1,800,000.00	2,065,000.00
1.2.7	Бусад мөнгөн зарлага	24,000.00	36,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны ЦМГ-ний дүн	(24,037.62)	(81,314,827.40)
3	САНХҮҮГИЙН ҮА-НЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	81,278,827.40
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	81,278,827.40
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ-ний дүн	-	81,278,827.40
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(24,037.62)	(36,000.00)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,317,445.47	13,293,407.85
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,293,407.85	13,257,407.85

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТОДРУУЛГА

2.1 МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд Касс болон харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөхөд өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай, богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ. Гадаад валютыг нэр төрөл тус бүрээр нэрийн данс нээж Монгол банкнаас зарласан тухайн үеийн ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Гадаад валютын үлдэгдлийг Монгол банкнаас зарласан ханшаар тухай бүр тэгшитгэн тооцоо хийж, гарсан зөрүүгээр тайлант хугацааны цэвэр орлого, зарлагад оруулна.

Тус байгууллага нь ХАС банк, Голомт банк, ХХБанк, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд харилцах данстай бөгөөд тайлант хугацааны эцэст дараах мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2024.12.31	2025.12.31
Харилцах		
Харилцах – 110201	1,105,756.03	1,100,756.03
Харилцах – 110202	10,954,493.03	10,935,493.03
Харилцах – 110203	36.15	36.15
Харилцах -110301	568,961.79	568,961.79
Харилцах – 110302	417,244.39	417,244.39
Харилцах – 110304	140,298.55	140,298.55
Харилцах -110305 ҮЦТХТ	16,000.00	16,000.00
Харилцах – 110306 ҮЦТХТ	42,408.90	42,408.90
Харилцах – 110307ҮЦТХТ	48,209.00	36,209.00
Харилцах дансны үлдэгдэл	13,293,407.85	13,257,407.85
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	13,293,407.85	13,257,407.85

Байгууллага нь харилцах дансны үлдэгдлийг аливаа зээлийн баталгаа болон бусдад барьцаалаагүй бөгөөд зарцуулалт нь хязгаарлагдаагүй болно.

2.2 ДАНСНЫ АВЛАГА

Дансны авлага гэж нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний үнэ, хүлээн аваагүй байгаа бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн тооцоо юм. Дансны авлагад үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлага, ногдол ашгийн авлага, үнэт цаасны хүүгийн авлага зэрэг дүн орно.

Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд харуулна.

2.3 ТАТВАР, НДШ-ИЙН АВЛАГА

Татвар, НДШ-ийн авлага гэж тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн татвар, НДШ-ийн төлбөртэй холбоотой үүссэн тооцоо юм. Татварын төрөл тус бүрээр данс нээж бүртгэх ба Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлнэ. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын

баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна. Тайлант хугацааны эцэст татвар, нийгмийн даатгалын шимтэгийн авлагын үлдэгдэл, ангилал дараах байдалтай байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2024.12.31	2025.12.31
Татварын авлага – ХХОАТ	177,128.25	177,128.25
Нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага	-	-
Нийт татвар, НДШ-ийн дүн	177,128.25	177,128.25

2.4 БУСАД АВЛАГА

Бусад авлагад үндсэн бус үйл ажиллагаанаас үүссэн авлагууд байх ба цэвэр боломжит үнэ цэнээр илэрхийлнэ. Дансны бусад авлагад бусад байгууллага, хувь хүн, холбоотой талд өгсөн 1 жил хүртэлх хугацаатай, нэг жилийн дотор эргэн төлөгдөх ажилчдаас авах авлага болон цалингийн урьдчилгааг бүртгэнэ.

2.5 БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Санхүүгийн хөрөнгө гэж тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан буюу түр зуур чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгийг ашиг олох зорилгоор зарцуулж буй үйл ажиллагааг хэлнэ. Бусад санхүүгийн хөрөнгөд 3 сараас нэг жилийн хугацаатай хадгаламж, богино хугацаат өрийн болон өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт хамаарна. Санхүүгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгахад СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга, СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр, НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулгыг дагаж мөрдөнө. Үнэт цаасаарх хөрөнгө оруулалт нь өрийн /бонд/ үнэт цаасаарх хөрөнгө оруулалт, өмчийн /хувьцаа/ үнэт цаасаарх хөрөнгө оруулалт гэсэн хэлбэртэй байна.

2.6 БАРАА МАТЕРИАЛ

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна. НББОУС 2 Бараа материалд заасны дагуу бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ. Бараа материалын цэвэр боломжит үнийг тайлант үе бүрийн эцэст тооцно.

Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авч ирэхтэй холбоотой гарсан зардлууд орно. Үйлчилгээний байгууллагын хувьд бараа материалын өртгийг үйлдвэрлэлийн өртгөөр хэмжих бөгөөд өртөгт нь үйлчилгээ үзүүлэхэд шууд оролцож буй ажилчдын хөдөлмөрийн болон бусад нэмэлт зардлуудыг хамруулна.

2.7 САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ

Санхүүгийн хөрөнгө гэж тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан буюу түр зуур чөлөөтэй байгаа мөнгөн хөрөнгийг ашиг олох зорилгоор зарцуулж буй үйл ажиллагааг хэлнэ. Санхүүгийн хөрөнгийг НББОУС 32-т хөрөнгө оруулалт гэж тодорхойлсон байна.

Үнэт цаасаарх хөрөнгө оруулалт нь өрийн /бонд/ үнэт цаасаарх хөрөнгө оруулалт, өмчийн /хувьцаа/ үнэт цаасаарх хөрөнгө оруулалт гэсэн хэлбэртэй байна.

Тус байгууллага нь санхүүгийн хөрөнгөд арилжааны үнэт цаас, өөрийн эзэмшиж байгаа үнэт цаас болон хөрөнгө оруулалтыг бүртгэдэг ба тайлант хугацааны эцэст дараах үлдэгдэлтэй байсан байна.

Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2024.12.31	2025.12.31
Арилжааны үнэт цаас	12,293,899.59	12,293,899.59
Борлуулахад бэлэн үнэт цаас	1,650,843,700.00	1,576,801,855.40
Нийт санхүүгийн хөрөнгийн дүн	1,663,137,599.59	1,589,095,754.99

2.8 УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

Урьдчилан төлсөн зардал/тооцоо гэж тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зардлыг балансын хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж үзүүлнэ. Ийм төрлийн зардлыг жинхэнэ хэрэгжилтэд суурилан дараагийн тайлант үеүдэд зардалд шингээнэ.

Мөн энэ ангилалд төлбөрийн баталгааны сан, барьцаа хөрөнгийн сан, эрсдэлийн сангуудад байршуулсан хөрөнгө буюу эрсдэлээс хамгаалахад зориулж тусгаарласан хөрөнгийг оруулж бүртгэнэ.

2.9 ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгөд нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах, ашиглалтын боломжит хугацаа нь хязгаарлагдмал бизнесийн хэвийн нөхцөлд худалдах зориулалтгүй үйлдвэрлэл, үйлчилгээний болон түрээслүүлэх, захиргааны зориулалтаар ашиглагдах элэгдлийн үндсэн дээр өртөг, зардалд анхны үнээ аажмаар шингээж байдаг биет хөрөнгүүд байна.

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн анхны өртөгт худалдан авсан үнэ, түүнийг бэлтгэхтэй холбогдон гарсан аливаа шууд зардлыг оруулах ба мөнгөн хөнгөлөлтийг хасаж тооцон бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцоолж, хөрөнгө бүрийн өртгийг түүний үлдэх өртөг хүртэл бууруулдаг.

Биет хөрөнгийг худалдан борлуулах буюу түүний ашиглалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөжгүй болсон үед данснаас хасах ба энэ үед үүссэн олз, гарзыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгийн үлдэгдэл, ангилал тайлант хугацааны эцэст дараах байдалтай байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2024.12.31	2025.12.31
Тавилга эд хогшил	6,500,000.00	6,500,000.00
Компьютер, бусад хэрэгсэл	3,228,800.00	3,228,800.00
Хуримтлагдсан элэгдэл	(5,435,102.02)	(7,380,702.02)
Нийт цэвэр үндсэн хөрөнгийн дүн	4,293,697.98	2,348,097.98

2.10 БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Биет бус хөрөнгөд биет шинж чанаргүй, тодорхойлогдох мөнгөн бус хөрөнгийг тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай, хөрөнгийн өртгийг найдвартай хэмжих боломжтой тохиолдолд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Бүртгэхдээ НББОУС-20-ийн дагуу уг хөрөнгийг бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Хэрэв анхны бодит үнэ цэнээр бүртгээгүй бол нэрлэсэн үнэ дээр зориулалтаар нь ашиглахад бэлэн болгохтой холбоотой шууд зардлуудыг нэмж бүртгэнэ.

2.11 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Урт хугацаат хөрөнгө оруулалтыг ихэвчлэн олж бэлтгэсэн өртгөөр нь дансанд бүртгэдэг. Урт хугацаат хөрөнгө оруулалтын зах зээлийн үнэ цэнэ буурч байгаа тохиолдолд үнийн бууралтыг хөрөнгө оруулалт тус бүрээр тодорхойлж, балансад хүлээн

зөвшөөрч тусгадаг. Урт хугацаат хөрөнгө оруулалтыг НББОУС 28 Хараат компани дахь хөрөнгө оруулалт, НББОУС 31 Хамтарсан үйлдвэр дэх хувь оролцоо, НББОУС 32 Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, СТОУС 7 Санхүүгийн хэрэглүүр: Тодруулга, СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүрийн дагуу бүртгэж, тусдаа санхүүгийн тайланд НББОУС 27 Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн дагуу толилуулна. Урт хугацаат хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалт бүрээр нь тооцохыг шаарддаг.

Эргэлтийн бус хөрөнгийн ангилалд хамаарах хөрөнгө оруулалтыг тайланд:

- Өртгөөр
- Дахин үнэлсэн үнээр
- Борлуулах хувьцааг багцаар нь тооцон олж бэлтгэх зардал ба зах зээлийн үнийн аль багаар тус тус үнэлж тусгана.

2.12 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

Хөрөнгийн үнийг өсгөх, түрээсийн орлого олох эсхүл аль алиных нь зорилгоор эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийг бүртгэх НББОУС 40 “Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө”-д заасны дагуу уг хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед бодит үнэ цэнэ эсхүл өртгөөр нь бүртгэнэ. Сонгосон загвараа хөрөнгө оруулалтын зориулалттай бүх үл хөдлөх хөрөнгө (үйл ажиллагааны түрээсийн хөрөнгөөс бусад)-нд хэрэглэнэ. Бодит үнэ цэний загварын дагуу хөрөнгийг анхны хэмжилтээс хойш бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Өртгийн загварын дагуу хөрөнгийг анхны хэмжилтийн дараа элэгдүүлсэн өртөг (хуримтлагдсан үнэ цэний бууралтын гарзыг хассан дүн)-өөр бүртгэнэ. Санхүүгийн байдлын тайланд уг хөрөнгийг дансны цэвэр дүнгээр нь харуулна.

2.13 ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГӨ

Хойшлогдсон татварын хөрөнгөнд хасагдах түр зөрүү болон ашиглагдаагүй татварын алдагдлыг дараагийн үе рүү шилжүүлэхтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын албан татварын дүн хамаарна. Хойшлогдсон татварын хөрөнгийг НББОУС 12 “Орлогын албан татвар”-ын дагуу тооцож бүртгэнэ.

Байгууллага нь хасагдах түр зөрүүг ашиглаж болохуйц хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалтай байгаа үед л хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хэрэв хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг ашиглах хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалгүй бол тэр хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулна. Энэхүү бууралтыг хангалттай хэмжээний татвар ногдуулах орлого олох магадлалтай болсон үед буцаана.

2.14 ДАНСНЫ ӨГЛӨГ

Дансны өглөг нь НББОУС-т зааснаар өнгөрсөн үйл, ажил гүйлгээний үр дүнд бий болсон, ирээдүйд зайлшгүй төлөх, бусдын өмнө хүлээсэн үүрэг буюу санхүүгийн хариуцлага мөн бөгөөд тухайн тайлант үеийн нэрлэсэн үнээр тайлагнадаг. Тус байгууллагын санхүүгийн тайланд дансны өглөг тайлант хугацааны эцэст дараах үлдэгдэлтэй байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2024.12.31	2025.12.31
Дансны өглөг - Адамас	45,688,270.00	45,688,270.00
Дансны өглөг – 22-р бааз ХК	19,279,749.00	19,279,749.00
Дансны өглөг – Иргэн Гүндэгмаа	33,607,240.00	33,607,240.00
Дансны өглөг – Иргэн Номундарь	209,051,678.38	290,330,505.78
Нийт дансны өглөгийн дүн	307,626,937.38	388,905,764.78

2.15 ЦАЛИНГИЙН ӨГЛӨГ

Ажилчин албан хаагчдад өгөх цалин, бусад хэлбэрийн хөдөлмөрийн хөлсний өглөгийг цалингийн өглөгөөр бүртгэх ба тайлант оны эцэст цалингийн өглөгийн үлдэгдэлгүй байсан байна.

2.16 ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨГЛӨГ

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), онцгой албан татвар (ОАТ)-ын өр, бусад татвар, төлбөр, хураамжийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдлүүд нь энэ дансны бүлэглэлд хамаарна. Улирал ба жилийн эцэс дэх төлөгдөөгүй татварын үлдэгдэл нь татварын байгууллагаас баталгаажуулсан үлдэгдэлтэй тэнцүү байна. Мөн цалингаас суутгасан болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй байгаа үлдэгдлээр санхүүгийн тайланд тусгагдах ба тайлант хугацааны эцэст татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлөгдөөгүй өр төлбөрийн үлдэгдэл дараах байдалтай байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2024.12.31	2025.12.31
Татварын өр - ХХОАТ	11,853,686.08	16,144,715.68
Нийгмийн даатгалын шимтгэлийн өр	24,836,599.32	461,763.32
Нийт татвар, НДШ-ийн өрийн дүн	36,690,285.40	16,066,479.00

2.17 УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхээс өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсхүл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж “Урьдчилж орсон орлого” дансанд бүртгэдэг. Энэ дансыг бараа, үйлчилгээ үзүүлсэн буюу орлого хэрэгжсэн үед холбогдох борлуулалтын орлогын дансыг бүртгэнэ.

2.18 БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Бизнесийн үйл ажиллагаанаас өөр чиглэлээр үүссэн өр, бизнесийн үйл ажиллагааны явцад үүссэн төрөл бүрийн суутгалууд, зардалд шингээж тооцсон төлөгдөөгүй өр, урт хугацаат өр төлбөрийн тайлант хугацаанд хамаарах хэсэг, худалдан авагчид болон ажиллагчдаас авсан буцаан төлөх мөнгөн барьцаа, холбоотой талаас авсан богино хугацаат зээл болон дээр тусгайлан толилуулснаас бусад богино хугацаат өр төлбөрийг бүртгэх ба бусад богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлгүй байна.

2.19 НӨӨЦ /ӨР ТӨЛБӨР/

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн үүрэг хариуцлагыг төлөх магадлалтай, төлбөрийн дүнг тооцоолох боломжтой болсон үед нь нөөц гэж хүлээн зөвшөөрч бүртгэх ба нөөцийн бүртгэлд НББОУС 37 “Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө”-г мөрдөнө.

2.20 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Урт хугацаат бонд, өрийн бичиг болон бусад урт хугацаат өр төлбөр, хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын өр гэж татвар ногдох түр зөрүүтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед төлөх орлогын албан татварын өрийн дүнг хэлнэ. Хойшлогдсон татварын өрийг НББОУС 12 Орлогын албан татварын дагуу тооцож бүртгэлд тусгана.

2.21 БУСАД УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

Бусад урт хугацаат өр төлбөр гэдэг нь бизнесийн үйл ажиллагааны хэвийн цикл эсвэл нэг жилийн аль уртад төлөгдөхгүй буюу 1 жилийн дотор одоо байгаа эргэлтийн хөрөнгөөр барагдахгүй үүрэг хариуцлага бөгөөд урт хугацаат бонд, өрийн бичиг болон бусад урт хугацаат өр төлбөрийн дүнг хэлнэ. Тус байгууллага нь бусад урт хугацаатай өр төлбөрийн дансанд холбоотой талд өгөх урт хугацаат өр төлбөрийг бүртгэнэ.

2.22 ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨР

Хойшлогдсон татварын өр гэж татвар ногдох түр зөрүүтэй холбоотойгоор ирээдүйн тайлант үед төлөх орлогын албан татварын өрийн дүнг хэлнэ. Хойшлогдсон татварын өрийг НББОУС 12 "Орлогын албан татвар"-ын дагуу тооцож бүртгэлд тусгана.

2.23 ЭЗДИЙН ӨМЧ

Өмчийг түүний нэрлэсэн үнээр тайлагнадаг. Нэрлэсэн үнээс илүүгээр төлөгдсөн дүнг нэмж төлөгдсөн капитал гэж бүртгэдэг. Ногдол ашгийг зарласан тайлант үед нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Аж ахуйн нэгжийн үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн дансны үнэ дахин үнэлгээний үр дүнд өссөн бол бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн өсөлтийн дүнг энэ дансанд хуримтлуулан бүртгэнэ. Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансыг бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - өсөлт, үнэ цэний бууралтын гарзны буцаалтын дүнгээр нэмэгдүүлнэ. Харин бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү - бууралт, үнэ цэний бууралтын гарз, хэрэгжсэн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнгээр энэ дансыг бууруулна. Эздийн өмчийн дансны ангилал, үлдэгдэл тайлант хугацааны эцэст дараах үлдэгдэлтэй болсон байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2024.12.31	2025.12.31
Эзний өмч	300,000,000.00	300,000,000.00
Эздийн өмчийн бусад хэсэг	1,650,843,700.00	1,576,801,855.40
Хуримтлагдсан ашиг / алдагдал	(615,231,889.11)	(677,435,710.11)
Тайлант үеийн хуримтлагдсан ашиг / алдагдал	(60,856,808.00)	(62,203,821.00)
Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг / алдагдал	(554,375,081.11)	(615,231,889.11)
Нийт эзний өмчийн дүн	1,335,611,810.89	1,199,366,145.29

2.24 ОРЛОГО БА ОЛЗ

Орлого ба олз гэдэг нь компанийн үйл ажиллагааны явцад тайлант хугацаанд бий болсон хөрөнгийн дотогш урсгал, өр төлбөр барагдуулалт болон өмчийн өсөлт хэлбэрээр эдийн засгийн өгөөж нэмэгдэхийг хэлнэ. Орлого нь өөртөө үйл ажиллагааны орлого болон бусад орлогыг хамааруулна. Мэргэжлийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх өгөөж нь үндсэн үйл ажиллагааны орлого болно.

Тайлангийн хугацаанд худалдсан бараа, бүтээгдэхүүн буюу гадагш үзүүлсэн ажил, үйлчилгээний орлого зэрэг байнгын, тогтмол үйл ажиллагаанаас олсон орлогыг борлуулалтын хөнгөлөлт, буцаалт болон үнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр орлогыг бүртгэнэ. Тайлант хугацаанд арилжсан үнэт цаас болон үнэт цаасны хүү, харилцахын хүүний орлого дараах байдалтай байсан байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2024.12.31	2025.12.31
Брокерын үйл ажиллагааны орлого	-	30,000.00
Нийт орлогын дүн	-	30,000.00

2.25 БУСАД ОЛЗ (ГАРЗ)

Бусад орлого ба олз гэдэг нь мэргэжлийн байгууллагын байнгын бус гэнэтийн ажил үйлчилгээнээс түүнчлэн хувь нийлүүлэгчдийн орлого, хөрөнгө оруулалтаас бусад тухайн тайлант хугацаанд мэргэжлийн байгууллагад нөлөөлөх бүх ажил гүйлгээ, үйл явдлын үр дүнд өмчид гарсан цэвэр өсөлт юм.

2.26 БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГ БОЛОН ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

Борлуулалт маркетинг болон ерөнхий ба удирдлагын зардлыг ажиллагчдын цалин, нийгмийн даатгал шимтгэл, албан татвар, төлбөр, хураамж, томилолт, бичиг хэрэг, шуудан холбоо, мэргэжлийн үйлчилгээ, сургалт, сонин сэтгүүл захиалга, даатгал, цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалт, засвар, элэгдэл хорогдол, түрээс, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ, тээвэр, шатахуун, хүлээн авалтын зардлууд, биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөөгүй судалгааны болон хөгжүүлэлтийн зардал болон бусад гэж дэлгэрэнгүй тодруулна. Тус байгууллагын хувьд тайлант хугацаанд борлуулалт, маркетинг болон ерөнхий удирдлагын зардал дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2024.12.31	2025.12.31
Ажиллагсдын цалингийн зардал	48,240,000.00	51,516,000.00
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	4,832,400.00	5,069,460.00
Албан татвар, төлбөр хураамж	1,800,000.00	2,065,000.00
Шуудан холбооны зардал	-	2,574,561.00
Мэргэжлийн үйлчилгээний зардал	24,000.00	36,000.00
Ашиглалтын зардал	4,987,608.00	-
Элэгдэл хорогдлын зардал	972,800.00	972,800.00
Нийт борлуулалт маркетинг болон ерөнхий удирдлагын зардлын дүн	60,856,808.00	62,233,821.00

2.27 БУСАД ЗАРДАЛ БА ГАРЗ

Бусад зардал ба гарз гэдэг нь үндсэн үйл ажиллагааг байнга явуулахын тулд бусад үйл ажиллагааг гүйцэтгэснээр хөрөнгө буурч өр төлбөр үүсэх явдал юм. Бусад зардал ба гарз нь мэргэжлийн байгууллагын байнгын бус буюу гэнэтийн ажил гүйлгээнээс түүнчлэн эздийн зардал буюу өгсөн хуваарилалтаас бусад тухайн тайлант хугацаанд мэргэжлийн байгууллагад нөлөөлөх бүх ажил гүйлгээ, үйл явдлын үр дүнд өмчид гарсан бууралт юм.

Эдийн засгийн үр ашгийн бууралт нь хөрөнгийн үнэлгээг бууруулах буюу өр төлбөрийг нэмэгдүүлж байгаа бөгөөд хэмжиж болохуйц байвал зардлыг хүлээн зөвшөөрнө.

2.28 ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

Орлогын татварын зардал (орлого) нь тайлант үеийн татварын зардал болон хойшлогдсон татварын зардал (орлого)-аас бүрдэнэ. Тайлант үеийн татварын зардал гэдэгт нийтлэг болон тусгай хувь хэмжээгээр ногдуулсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дүнг хэлнэ.

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1 ОРШИЛ

Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус компанийн Гүйцэтгэх захирал Л.ГҮНДЭГМАА танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн шалгагдагчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

3.2 АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

Бид аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д заасны дагуу Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Монголсекюритиес ҮЦК ХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь хараат бус аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2026 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс 2026 оны 8 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2026 оны 8 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Монголсекюритиес ҮЦК ХК нь 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ЦЭБЭ Консалтинг аудит ХХК-д 2026 оны 8 дугаар сарын 17-ны өдөр файлаар mnnnergui@gmail.com цахим хаягаас ирүүлсэн байна.

3.3 АУДИТЫН ЯВЦАД МӨРДСӨН БОДЛОГО, ЖУРАМ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

3.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Тус байгууллага нь 1999 оны 12 дугаар сарын 15-ны өдөр анх байгуулагдсан. 2007 оны 8 дугаар сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны даргын 112 дугаар тогтоолын дагуу ТЗ 301/14 дугаараар үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.

Монголсекюритиес ҮЦК ХК нь "Монгол улсын үнэт цаасны зах зээлийг сонгодог утгаар хөгжүүлэх, хөрөнгө оруулагчдыг хүндлэн дээдлэх, үнэт цаасны шударга өрсөлдөөнт зах зээлийг бий болгож харилцагчдыг чанартай, түргэн шуурхай, найдвартай үйлчилгээгээр хангах"-д оршино гэж үйл ажиллагааныхаа зорилгоо тодорхойлсон байна.

Монголсекюритиес ҮЦК ХК нь байгууллагын дүрэмдээ үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдад үнэт цаас худалдан авахад зуучлах
- Хөрөнгө оруулагчдын нэрийн өмнөөс Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжаанд оролцох
- Компанийн харилцагчдын үнэт цаас эзэмшлийн бүртгэлийг хөтөлж мэдээлэл боловсруулах
- Үнэт цаасны зах зээлтэй холбогдолтой асуудлаар харилцагчдад үнэн зөв мэдээлэл, зөвлөгөө өгөх
- Үнэт цаасны зах зээлтэй холбогдолтой төрөл бүрийн гарын авлага боловсруулан гаргах

Тус байгууллага нь Үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулиуд болон татвар, нийгмийн даатгалын багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагаа нь тогтвортой ажиллаж байгаа болно.

Байгууллагын улсын бүртгэлийн дугаар: **9010001014**
Байгууллагын регистрийн дугаар: **2587904**

3.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс шалгаагдагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг хангалттай гэж үзсэн болно.

Тус байгууллагад өнөөдрийн байдлаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй хэдий ч Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг судалж үзэхэд батлагдсан бодлого, журамд нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

3.6 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Аудитаар Монголсекюритиес ҮЦК ХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

3.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны жилийн эцсээрх санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,604.9 сая төгрөгөөс материаллаг байдлыг 16.1 сая төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

3.8 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монголсекюритиес ҮЦК ХК-ийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 75.1 сая төгрөгөөр буюу 4.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан санхүүгийн хөрөнгө, дансны өглөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, эздийн өмчийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13.2	13.3	-
Татвар, НДШ-ийн авлага	0.2	0.2	-
Санхүүгийн хөрөнгө	1,663.1	1,589.1	(74.0)
Үндсэн хөрөнгө	3.3	2.3	(1.0)
Нийт хөрөнгө	1,679.9	1,604.9	(75.0)
Богино хугацаат өр төлбөр	344.3	405.5	61.2
Эздийн өмч	1,335.6	1,199.4	(136.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,679.9	1,604.9	(75.0)

Дансны авлагад татварын байгууллагаас авах ХХОАТ-ын илүү төлөлт 177.1 мянган төгрөг бүртгэгдсэн байх ба харьяа татварын хэлтэстэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Борлуулах зорилгоор бэлтгэсэн болон арилжааны үнэт цаас 1,589.1 сая төгрөг болж 74.0 сая төгрөгөөр буурсан байна.

Эргэлтийн бус хөрөнгө 2.3 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд байгуулсан элэгдлээс шалтгаалсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн данс нь 61.2 сая төгрөгөөр өссөн нь хувь хүнд өгөх өр 81.3 сая төгрөг, татварын байгууллагад төлөх өр 4.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, Нийгмийн даатгалын байгууллагад төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн өрнөөс 24.4 сая төгрөгийг төлснөөс шалтгаалсан байна.

Эздийн өмчийн өөрчлөлт нь тайлант үеийн алдагдлын хэмжээ 62.2 сая төгрөгөөр нэмэгдсэн, эздийн өмчийн бусад хэсэг 74.0 сая төгрөгөөр буурсан зэргээс шалтгаалжээ.

3.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар

- Мөнгөн хөрөнгийн гадаад валютаарх дансны үлдэгдэлд тайлант хугацааны эцэст Монгол банкнаас зарласан гадаад валютын төгрөгөөр тооцсон

ханшийг үндэслэн гадаад валютын ханшийн тэгшитгэл хийж, бодит бус ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүрхтгэсэн эсэх;

- Санхүүгийн бүрдэл хангаагүй бичиг баримтаар тохируулгын бичилт, гүйлгээ хийсэн эсэх;
- Харилцах дансаар хийгдсэн гүйлгээг тооцооны дансаар дамжуулан зардлын дансанд бичилт хийсэн эсэх;
- Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг харилцагч байгууллагуудаар баталгаажуулсан эсэх асуудлуудыг авч үзнэ.

4. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ТАЛААР:

Материаллаг байдлын түвшинд хүрсэн алдаа зөрчил илрээгүй байна.

5. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДЛУУД:

Аудит хийгдсэний дараа материаллаг түвшингийн хэмжээнээс давсан алдаа зөрчлүүд гараагүй болно.

Захирал



Д.ЭНХБААТАР

/Аудитор, МНБ/